



Олон Улсын
Улаанбаатарын Их Сургууль
국제울란바타르대학교



한국학중앙연구원
THE ACADEMY OF KOREAN STUDIES

2023년 제2차 한국학 세미나

2차 주제: 한국어의 몽골어 전사법

일시 : 2023.03.15(수) 16시

장소 : 국제울란바타르대학교 본관 A403호

제 2 차 한국학 세미나

주제: 한국어의 몽골어 전사법

일시 : 2023.03.15(수) 16 시

장소 : 국제울란바타르대학교 본관 A403 호

주최 : 국제울란바타르대학교 한국학연구소, 대학원(한국학과)

주관 : 국제울란바타르대학교 해외한국학증핵대학육성사업단

강사 소개



ERDENECHIMEG Gotov 교수

몽골국립대학교 문학박사

소속: 몽골 국립대학교. 인문대학 아시아 학과 교수

주 연구분야: 한-몽 역사, 13-14 세기 한-몽 역사



URTNASAN Davaajav 전임연구원

서울대학교 언어학 박사

소속: 몽골과학원 언어문학연구소, 전임연구원

주 연구분야: 몽골어 모음약화, 실험은성학적 연구

이 자료집은 2022 년 대한민국 교육부와 한국학중앙연구원(한국학진흥사업단)을
통해 해외한국학중핵대학육성사업의 자원을 받아 수행된 연구임

(AKS-2022-OLU-2250006)



국제울란바타르대학교, 한국학 연구소
한국학진흥사업단 '해외 한국학 중핵대학 육성 사업'



한국학 2차 세미나

한국어의 몽골어 전사법

일시

2023.03.15(수)
16:00-17:00

장소

국제울란바타르대학교 A 동, 403
온라인 줌 병행

시간	내용
15:30-15:55	등록, 다과
16:00-16:05	인사 사업단장: 강선화(국제울란바타르대학교)
16:05-16:35	강사: 게. 에르덴치멕(국립대학교) 주제: 송그도인가? 송도인가?
16:35-16:45	질의 응답
16:45-17:15	강사: 데. 오르트나상(과학원 언어문학연구소) 주제: 외래어 표기법 -한국어 중심으로-
17:15-17:25	질의 응답
17:25-17:30	기념 촬영 및 공지

ZOOM ID: 875 5389 8058
PW: 12345

등록 QR code



✉ koreanstudies@ulaanbaatar.edu.mn

🌐 www.ksc.iuu.mn

☎ 9100-9474, 8873-7720

📌 Korean Studies Center



Олон Улсын Улаанбаатарын Их сургууль, Солонгос судлалын хүрээлэн
Их сургуулийг түшиглэн солонгос судлалыг хилийн чанадад хөгжүүлэх төсөл



СОЛОНГОС СУДЛАЛЫН ХОЁРДУГААР СЕМИНАР

СОЛОНГОС ХЭЛНИЙ ГАЛИГИЙН ЗАРИМ АСУУДАЛ

ХЭЗЭЭ

2023.03.15(Лхагва)
16:00-17:30 цаг

ХААНА

ОУУБИС-ийн А байр, 403
Онлайн зүүм хамт

Цаг	Хөтөлбөр
15:30–15:55	Бүртгэл, coffee break
16:00–16:05	Нээлтийн үг Төслийн удирдагч: КАН СОНЬ ХУА(ОУУБИС, доктор)
16:05–16:35	Лектор: Г. ЭРДЭНЭЧИМЭГ(МУИС, доктор) Сэдэв: СОНГДО ЮУ? СОНДО ЮУ?
16:35–16:45	Асуулт, хариулт
16:45–17:15	Лектор: Д. УРТНАСАН(ШУА, ХЗХ, доктор) Сэдэв: ГАДААД ҮГ ГАЛИГЛАХ АРГА –Солонгос хэлний жишээгээр–
17:15–17:25	Асуулт, хариулт
17:30	Дурсгалын зураг, зарлал

Онлайн(ZOOM)

ID: 875 5389 8058

PW: 12345

✉ koreanstudies@ulaanbaatar.edu.mn

🌐 www.ksc.iuu.mn

☎ 9100-9474, 8873-7720

📘 Korean Studies Center

Бүртгэлийн
QR code



Солонгос хэлний үгийг монгол кирилл үсгээр галиглах тухайд

Г. Эрдэнэчимэг Ph.D

МУИС, Ази судлалын тэнхим

Алив нэг хэлний үгийг харь бичиг үсгээр тэмдэглэх галигийг авианы галиг(轉音法, transphonation), үсгийн галиг(轉字法, transliteration) гэж хоёр ангилдаг. Үсгийн галиг гэдэг бол хэлбэрийг үл алдагдуулах зарчимд үндэслэн нэг хэлний бичгийн тогтолцоог өөр хэлний бичиг үсгээр тэмдэглэхдээ авианы өөрчлөлтийг үл харгалзан нэг үсгийг нэг л үсэгтэй дүйлгэн тэмдэглэх аргыг хэлнэ. Харин авианы галиг гэдэг бол дуудлагыг үл алдагдуулах зарчимд үндэслэн авианы өөрчлөлтийг тусгаж галиглах аргыг¹ хэлэх тул нэг үсгийг хоёр, гурван ч үсэгтэй дүйлгэн тэмдэглэж болно.

Галигийг хэн хүн дураараа зохиодог бус. Эх хэлээ сайн мэдэхээс гадна гадаад хэлийг тогтолцоотой сурсан судлаач, эрдэмтэн хүн тодорхой зарчимд үндэслэн зохиодог.² 2005 онд эрдэмтэн Б. Сумьяабаатар³ солонгос хэлний үгийг монгол кирилл үсгээр галиглах галигийг зохиов. Энэ галигийн үндсэн зарчим нь :

1. Авианы ижил байршилд байгаа бол нэг янзаар буулгах
2. Үгийн утга ялгадаг авиалбар тус бүрийг өөрөөр галиглах
3. Кириллээр галигласан үсгийг буцаагаад солонгос үсгээр сольж бичихэд алдаагүй байх явдал юм.
4. Монгол галиг орос, ром үсгийн галигтай таарах албагүй.

Хэрэв үндсэн зарчмынхаа гуравдугаар зүйлийг чандлан баримтлаваас үсгийн галиг гэж хэлмээр. Хэдийгээр ийнхүү галиглах журмыг гаргасан боловч холбогдох хүмүүсийн хүрээнд шүүмжлэн хэлэлцүүлэх, нийтэд танилцуулах ажил хийгээгүй тул уг журмыг тун цөөхөн багш, судлаач мөрдөж ирэв.

“Солонгосын түүх” номд⁴ гарах оноосон нэрийг уг галигаар хэрхэн галигласныг үзүүлбэл,

Сол. 함경 мон. Хамгйөн (ярианы хэлнээ Хангйөн) ; сол. 종성 мон. Чонсөн ; сол. 동관지 мон. Тонгуанъжинъ ; сол. 길림성 мон. Киллимсөн ; сол. 안도 мон. Аньдо ; сол. 석문산촌 мон. Сөгмүнъ (Сөмүнъ) санъчхонъ ; сол. 굴포 мон. Күлпхо ; сол. 충천 мон. Чхүнчхөнъ ; сол. 공주 мон. Конжү ; сол. 석장 мон. Сөгжан ; сол. 승리 мон. Сынри (Сынни) ; сол. 평양 мон. Пхйөн-Ян (Пхйөнян гэж залгаж бичвэл дуудлага буруутна) ; сол. 만달 мон. Мандал ; сол. 두루봉 мон. Түрүбон ; сол. 만포 мон. Маньпхо ; сол. 강원

¹ <https://namu.wiki/국어의 로마자 표기법>

² Ш. Эгшиг, Галигийн тухай, Хятад хэлний үеийн галиг, монгол хэлээр галиглах журам, Монгол, хятад хэлний орчуулагчдын холбоо, 2016 он

³ Б. Сумьяабаатар, Г. Эрдэнэчимэг, Солонгос оноосон нэрийг монгол кирилл үсгээр галиглах нь, Солонгос судлал, МУИС, ГХСС, 2005, 8-23 дугаар тал.

⁴ Г. Эрдэнэчимэг, Солонгосын түүх, Тэргүүн ба дэд дэвтэр, Адмон, 2006 он

мон. Канвөнъ ; сол 오산 мон. Осанъ ; сол 부산 мон. Пусанъ ; сол 동삼 мон. Тонсам ; сол 경산 мон. Кёнсанъ ; сол 대마 мон. Тайма (ТЕМА) ; сол 청호 мон. Чхонхо (Цонхо) ; сол 암사 мон. Амса ; сол 미사 мон. Миса ; сол 농포 мон. Нонпхо ; сол 지탑 мон. Житхаб ; сол 시/도 мон. Сидо (Шидо) ; сол 교동 мон. Кёдон ; сол 부여 мон. Пүйё ; сол 예맥 мон. Йемайг (ЙемЕг) ; сол 임둔 мон. Имдунъ ; сол 진번 мон. Жиньбөнъ (Жинбөнъ) ; сол 진국 мон. Жиньгүг (Жингүг) ; сол 아사달 мон. Асадал гэх мэт.

Солонгос хүний овог нэр:

Сол. 강 봉원 мон. Кан Бонвөнъ ; сол. 강 선엽 мон. Кан Сөнъ-йёб ; сол. 강선화 мон. Кан Сөнъхуа ; сол. 강 신 мон. Кан Синъ (Шинъ) ; сол. 고 현미 мон. Ко Хйёнъми ; сол. 계로이 мон. Кйэ Ро-и ; сол. 권 성훈 мон. Квөнъ Сөнхунъ ; сол. 권 지현 мон. Квөнъ Жихйёнъ ; сол. 김 경한 мон. Ким Гйёнханъ ; сол. 김 광민 мон. Ким Гуанминъ (Кин Гуанминъ) ; сол. 김 기석 мон. Ким Гисөг ; сол. 김 기선 мон. Ким Гисёнъ ; сол. 김기성 мон. Ким Гисён ; сол. 김 대수 мон. Ким Дайсү (ДЕ-) ; сол. 김 대현 мон. Ким Дайхйёнъ (ДЕ-) ; сол. 김대호 мон. Ким Дайхо (ДЕ-) ; сол. 김 방한. мон. Ким Банханъ ; сол. 김 상규 мон. Ким Сангю ; сол. 김 상배 мон. Ким Санбайш (-БЕ) ; сол. 김 선미 мон. Ким Сөнъми (Сөнми) ; сол. 김 수정 мон. Ким Сүзөн ; сол. 김 연진 мон. Ким Йёнъжинъ ; Сол. 김 유혁 мон. Ким Юхйөг ; Сол. 김 정구 мон. Ким Жёнгү ; Сол. 김 정은 мон. Ким Жён-ынъ (Жёнынъ гэж хамт бичвэл дуудлага өөрчлөгдөнө) ; Сол. 김 정일 мон. Ким Жён-Ил (Ким Жөнил гэж хамт бичвэл дуудлага өөрчлөгдөнө) ; Сол. 김 지현 мон. Ким Жихйёнъ ; Сол. 김 완검 мон. Ким Ваньгйём ; Сол. 김 일성 мон. Ким Илсөн ; Сол. 김 주원 мон. Ким Жүвөнъ ; Сол. 김 창유 мон. Ким Чхан-ю (Ким Чханю гэж хамт бичвэл дуудлага өөрчлөгдөнө) ; Сол. 김 충민 мон. Ким Чхунминъ ; Сол. 김 태은 мон. Ким Тайынъ (ТЕ-) ; Сол. 김 학선 мон. Ким Хагсөнъ ; Сол. 김 현숙 мон. Ким Хйёнъсүг ; Сол. 김 현정 мон. Ким Хйёнъжөн ; Сол. 노 계현 мон. Но Гйэхйёнъ ; Сол. 노 무현 мон. Но Мүхйёнъ ; Сол. 류 병재 мон. Рю Бйёнжай (-ЖЕ-) ; Сол. 문 주현 мон. Мүнъ Жүхйёнъ ; Сол. 박 경윤 мон. Паг Гйён-юнъ (Гйёнюнъ гэж цуг бичвэл дуудлага өөрчлөгдөнө) ; Сол. 박 미경 мон. Паг Мигйён (Пан Мигйён) ; Сол. 박 병욱 мон. Паг Бйён-Үг (Бйөнүг гэж цуг бичвэл дуудлага өөрчлөгдөнө) ; Сол. 박 선희 мон. Паг Сөнъхый ; Сол. 백 기준 мон. ПЕг Гижүнъ ; Сол. 서 응영 мон. Сө Ын-йён (Бйён гэж цуг бичвэл дуудлага өөрчлөгдөнө) ; Сол. 서 정원 мон. Сө Зөнвөнъ ; Сол. 손 상대 мон. Сонъ Сандай (-ДЕ) ; Сол. 송 병구 мон. Сон Бйөнгү ; Сол. 송 보기 мон. Сон Боги ; Сол. 송 의민 мон. Сон Ыйминъ ; Сол. 송 의정 мон. Сон Ыйзөн ; Сол. 송 화섭 мон. Сон Хуасөб ; Сол. 신 상균 мон. Синъ Сан гюнъ ; Сол. 신 수정 мон. Синъ Сүзөн (Шинъ-) ; Сол. 신 용하 мон. Синъ Ёнха (Шинъ-) ; Сол. 신 종한 мон. Синъ Жонханъ (Шинъ-) ; Сол. 심 재용 мон. Сим Жайён (Шим Жайён) ; Сол. 양 혜숙 мон. Ян Хйэсүг ; Сол. 여 병무 мон. Йё Бйөнмү ; Сол. 오 현주 мон. О Хйёнъжү ; Сол. 우 명훈 мон. У Мйөнхүнъ ; Сол. 우 미영 мон. У Ми-йөн ; Сол. 유 권중 мон. Ю Гвөнъжон ; Сол. 유 승의 мон. Ю Сынхый ; Сол. 유 원수 мон. Ю Вөнъсү ; Сол. 윤 경아 мон. Юнь Гйён-а (Гйёна гэж хамт бичвэл дуудлага өөрчлөгдөнө) ; Сол. 윤 명숙 мон. Юнь Мйөнсүг ; Сол. 윤 순제 мон. Юнь Сүнъжэ ; Сол. 윤 여정 мон. Юнь Йёзөн ; Сол. 윤 현철 мон. Юнь Хйёнъчхөл ; Сол. 윤 형원 мон. Хйёнвөнъ ; Сол. 윤 흥노 мон. Юнь Хынно ; Сол. 이 계심 мон. И Гйэшим ; Сол. 이 기문 мон. И Гимүнъ ; Сол. 이 미숙 мон. И

Мисүг; Сол. 이 선복 мон. И Сёнъбог ; Сол. 이 선아 мон. И Сёнъ-а (Сёна); Сол. 이 성규 мон. И Сёнгю; Сол. 이 승민 мон. И Сынминь; Сол. 이 영숙 мон. И Йёнсүг ; Сол. 이 우정 мон. И Үзөн ; Сол. 이 윤아 мон. И Юнь-а (Юна) ; Сол. 이 은수 мон. И Ыньсү ; Сол. 이 은정 мон. И Ыньзөн ; Сол. 이 종은 мон. И Жон-ынъ (*Жонынь гэж цуг бичвэл дуудлага өөрчлөгдөнө*) ; Сол. 이평래 мон. И Пхйёнрай (*ПхйённЕ*) ; Сол. 이혜영 мон. И Хйэ-йён (-ен) ; Сол. 장 장식 мон. Чан Жансиг (-шиг) ; Сол. 장 시온 мон. Чан Чхүнсиг (-шиг); Сол. 정 은주 мон. Чён Ыньжү ; Сол. 조 장현 мон. Чо Жанъхйёнъ ; Сол. 주 채혁 мон. Чү Чхайхйөг (*Чх Ехйөг*) ; Сол. 지 경구 мон. Жи Гйёнгү ; Сол. 최기호 мон. Чхой Гихо ; Сол. 최 미영 мон. Чой Ми-йён ; Сол. 최 서면 мон. Чхой Сөмйөнъ ; Сол. 최 연옥 мон. Чхой Йёнъ-ог (*Йёног*) ; Сол. 최 호윤 мон. Чхой Хоюнь ; Сол. 한 상진 мон. Ханъ Санжинъ ; Сол. 허 윤선 мон. Хө Юньсөнъ ; Сол. 허 응 мон. Хө Үн ; Сол. 현 주영 мон. Хйөнъ Жү-йён ; Сол. 홍 기문 мон. Хон Гимүнь ; Сол. 홍 길동 мон. Хон Гилдон ; Сол. 홍 복원 мон. Хон Богвөнъ ; Сол. 홍 승의 мон. Хон Сынхый ; Сол. 홍 원기 мон. Хон Вёнъги (Вёнги) ; Сол. 홍 인표 мон. Хон Инъпхё гэх мэт.

Солонгос номын нэр:

Сол. 고려사 мон. Корйёса ; Сол. 동국병감 мон. Тонгүгпйёнгам ; Сол. 몽어노걸대 мон. Мон-ө Ногөлдай (-дЕ) ; Сол. 몽어유해 мон. Мон-ө юхай (-хЕ) ; Сол. 첩해몽어 мон. ЧхөбхЕмон-ө гэх мэт

Солонгос сургуулийн нэр:

Сол. 강원 мон. Канвөнъ ; Сол. 건국 мон. Кёнъгүг ; Сол. 경희 мон. Кйөнхый ; Сол. 단국강원 мон. Танъгүг (*Тангүг*) ; Сол. 부산 мон. Пүсанъ ; Сол. 상명 мон. Санмйён ; Сол. 서강 мон. Сөган ; Сол. 서울 мон. Сөүл ; Сол. 연세 мон. Йёнъсэ ; Сол. 제주 мон. Жэжү (*Жээжүү*) ; Сол. 중앙 мон. Чүн-ан (*Чүнан гэж хамт бичвэл дуудлага өөрчлөгдөнө*) гэх мэт

Солонгос пүүс хоршооны нэр:

Сол. 삼성 мон. Самсөн ; Сол. 현대 мон. Хйёндай (-дЕ) ; Сол. 대우 мон. Тай-ү (*ТЕ-ү*) ;

Эндээс үзэхэд авианы өөрчлөлтийг тусгасан байна. Харин үндсэн зарчмын 3-р зүйлийг харахаар үсгийн галиг мэт. Өөрөөр хэлбэл, кириллээр галигласан үсгийг буцаагаад солонгос үсгээр сольж бичихэд алдаагүй байх нөхцөлийг ямар үед хангах вэ гэхээр авианы өөрчлөлтийг тусгахгүй байх ёстой. 승리-г Сынни гэж галиглаад буцаагаад солонгос үсгээр сольвол 승니 болж хувирна. Тэгэхээр энэ нь авианы болон үсгийн галиг хольсон байна. Бид энэ галигт авианы өөрчлөлтийг огт тусгахгүй гэж заагаад эрдэм шинжилгээнд хэрэглэх боломжтой.

БНСУ-д солонгос хэлний үгийг латинаар галиглахдаа авианы галигийг, харин гадаад хэлний үгийг тэмдэглэхдээ авианы болон үсгийн галигийг хольж хэрэглэдэг. Гэвч нэг хэлний дуудлагыг харь хэлний бичиг үсгээр, дуудлагад аль болох ойр тэмдэглэх нь зарим тохиолдолд боломжгүй учраас аливаа галиг зөрчил агуулж байдаг бөгөөд тэр хэрээр маргаантай.

Манайд уг галигтай харьцуулалт хийхүйц өөр галиг хараахан зохиогдоогүй байгаа тул БНСУ-ын солонгос үгийг ром үсгээр галиглах галигтай⁵ танилцъя. БНСУ-д 1959 оноос 1984 оныг хүртэл Соёл, Боловсролын Яамнаас гаргасан Хангыл, ром үсгийн галигийг (МОЕ, Mode of Education, 1959-SK) мөрдөж байжээ. 1988 оны Сөүлийн Олимпийн бэлтгэл ажлын хүрээнд 1984 онд Мэжюн Рэшавөгийн галиг (McCune-Reischauer romanization)-ийг түр хэрэглэсэн ч 90-ээд оноос дэлгэрсэн компьютерын хэрэглээнд тохиромжгүй, солонгос хүнд ойлгомж муутай зэрэг шалтгааны улмаас хэд хэдэн удаа мэргэжилтнүүдээр хэлэлцүүлсний эцэст БНСУ-ын Соёл, Спорт, Аялал жуулчлалын Яамнаас “Солонгос хэлийг ром үсгээр галиглах журам”-ыг 2000 оны 7-р сарын 7-ноос мөрдүүлэхээр журамлажээ. Өмнө мөрдөж ирсэн МОЕ-аас юугаараа ялгаатай вэ гэвэл, дэвсгэр үсгийн дуудлагыг тэмдэглэхдээ авианы галигийг хэсэгчлэн зөвшөөрсөн байна.

Уг журамд галиглах үндсэн зарчмыг дараах хоёр зүйлээр тодорхойлсон.

1. Солонгос хэлний үгийг ром үсгээр галиглахдаа солонгос хэлний төв аялгууны дуудлагын дагуу тэмдэглэх
2. Ром үсгээс өөр тэмдэглэгээ аль болох хэрэглэхгүй байх.

Үндсэн зарчмаас зөрөх зүйлийг тусгайлан заасан бөгөөд тэдгээрийг дурдъя.

1. ‘— | ’ нь ‘и’ гэж дуудагдах хэдий ч ‘ui’ гэж тэмдэглэнэ.
2. Урт эгшгийг тэмдэглэхгүй.
3. Эгшгийн өмнө орсон ‘ㄱ, ㄷ, ㅂ’-ыг ‘g, d, b’-гээр, гийгүүлэгчийн өмнө орох юм уу эсвэл дэвсгэрлэж орсон байвал ‘k, t, p’-гээр тэмдэглэнэ.
4. ‘ㄹ’ нь эгшгийн өмнө орвол ‘r’-р, гийгүүлэгчийн өмнө орвол ‘l’-р тэмдэглэнэ. ‘ㄹ’-ээр эхэлсэн үеийн өмнө дэвсгэрлэж орсон ‘ㄴ’ гийгүүлэгч ‘ㄹ’-тэй ижилсэх тохиолдолд ‘ll’ гэж тэмдэглэнэ гэж заажээ.

Журмын 3-р бүлэгт авианы хувиралтыг хэрхэн тэмдэглэхийг заасан байна. Тухайлбал,

백마 [뱅마] Baengma	신문로[신문노] Sinmunno
학여울[항녀울] Hangnyeoul	알약 [알락] allyak
해돋이 [해도지] haedoji	맞히다 [마치다] machida
종고 [조코] joko	놓다[노타] nota

БНСУ-ын эрдэмтэн судлаачид дунд интернэт орчинд солонгос үгийг товчилж бичих зэргээр солонгос хэлний амин сүнс болсон зөв бичих дүрмийг үл тоон эх хэлээ сүйтгэж байхад дээр нь нэмээд ром үсгээр галиглах галигаар бүр ч системтэйгээр сүйрүүлж байна гэж үздэг хүн олон. Тэд :

⁵ 국어의 로마자 표기법, 문화체육관광부, (국어정책과), 044-203-2537

1. Солонгос хэлний авиаг сүйтгэж байна. **중로** гэж бичээд **중노** гэж дуудах тул дуудлагаар нь тэмдэглэсний улмаас үсэг тус бүрийн шинж чанар алдагдана. Тэгэхээр солонгос үсгийг ром үсгээр сольсны дараа буцаагаад солонгос үсгээр солиход зуун хувь алдаагүй байх аргагүй.
2. Үеийг сүйтгэж байна. Солонгос хэл бол гийгүүлэгчийг эгшгээр амилуулах замаар бүтээх үеэс бүрэлдэн тогтдог. Үеийн заагийг устгавал утга болоод дуудлага нь задгайрна. Энэ зарчмыг үл тоон тэмдэглэсэн Anam-dong нь **안암동**, **아남동** хоёрын аль нь вэ гэдгийг мэдэх аргагүй тул утга болоод дуудлага ч тодорхой бус⁶ гэх зэргээр шүүмжилдэг.

Тэгэхээр бид энэ байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр эрдэм шинжилгээний ажилд одоо мөрдөж буй үсгийн галигийг сайжруулах, олон нийтийн хэрэглээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ашиглах авианы галигийн журмыг шинээр гаргаад холбогдох хүмүүсээр хэлэлцүүлэх, зохих байгууллагаар батлуулах, цаашилбал хэрэглэж хэвшүүлэх шаардлагатай байна. Бид эхлээд монгол кирилл үсгээр солонгос хэлийг, ялангуяа оноосон нэрийг галиглахад санал зөрж болзошгүй жишээг дурдая.

1. Эгшиг авиаг галиглахад гарах асуудал

Солонгос хэлэнд дан 10 эгшиг (ㅏ, ㅑ, ㅓ, ㅕ, ㅗ, ㅛ, ㅜ, ㅠ, ㅡ, ㅣ), давхар 11 (ㅑ, ㅓ, ㅕ, ㅗ, ㅛ, ㅜ, ㅠ, ㅑ, ㅓ, ㅕ, ㅗ, ㅛ, ㅜ, ㅠ, ㅡ, ㅣ) байдаг бол кирилл монгол бичгийн дүрмээр үндсэн 7 эгшиг (а, э, и, о, у, ө, ү) ба туслах 6 (я, е, ё, ю, й, ы) эгшигтэй.

- 1.1 Авианы ямар байрлалд байгаагаас хамааран ㅏ нь о ба ө хоёрын аль нэгээр, ㅓ нь у ба о хоёрын аль нэгээр дуудагдах тул аль үсгээр тэмдэглэх вэ гэдгийг шийдэх хэрэгтэй болно. Монгол, солонгос хоёр хэл хоёулаа эгшиг зохицох ёс бүхий хэл бөгөөд ㅏ эгшиг нь **эм эгшиг** гэдгийг анхаарах хэрэгтэй.
- 1.2 Бид дан эгшиг ㅑ, ㅓ -ийг э, ай гэж галиглаж ирэв. ㅑ -ийг хос эгшгээр тэмдэглэхээр а-г нь илүү тод дуудах талтай.
- 1.3 ㅓ -ийг ой-гоор галиглахаар заасан боловч уэ-гээр галиглавал дуудлагадаа илүү ойр.

2. Гийгүүлэгч авиаг галиглахад гарах асуудал

- 2.1 Дан болон давхар, хүчлэг гийгүүлэгчийг ялган тэмдэглэх талаар маргаантай. Гадаад хүн дуудлагыг нь ялгаж чадахгүй эдгээр гийгүүлэгчийг ялгаж галиглах гээд улам будлиантуулж байна гэж үзэн к, г хоёр үсгээр тэмдэглэх санал БНСУ-д илүү давамгайлж буй.
- 2.2 ㄴ ба ㅇ -ийг хэрхэн ялгаж галиглах вэ гэдэг асуудал хамгийн их маргаантай. ㄴ нь монгол хэлний хэлний үзүүрийн н, ㅇ нь хэлний угийн н-тэй төстэй. ㅇ -ийг Б. Сумьяабаатарын галигт н-ээр галигласан боловч олон нийтийн хэрэглээнд нг-ээр

⁶ 김선일, 한글을 파괴하는 국어의 로마자 표기법, 경향신문, 2016.09.25

тэмдэглэж буй нь учир дутагдалтай. Хэлний угийн н-ийг н гэж тэмдэглэхээр хэлний үзүүрийн н-ийг яаж ялгах вэ гэдэг асуудал гарна.

Тухайн хэлний төв аялгууны дуудлагыг гол хэмжүүр болгодог тул галиг нь хамгийн их маргаан дагуулдаг учир судлаачдын зохиосон галиг шүүмжлэлд их өртөхийн хэрээр дагаж мөрдөх нь ч сул байдаг. Монгол кирилл үсгээр галиглах галигийг зохиогоод хэдийнээ арав гаруй жил болсон боловч түүнийг дагаж мөрдөх нь ч мөн адил тааруу байна. Уг галигийг эрдэм шинжилгээний бүтээлд ашиглах нь зохистой.

Өнөөдөр манай телевиз радиогоор Умард болон Өмнөд Солонгосын нийгэм, улс төрийн мэдээг бэлтгэж буй орчуулагч, редактор (интернет сайт) нар солонгос хэлний мэдлэггүй тул голцуу орос, англи хэлний сурвалжаас мэдээг бэлдэж байна. Тухайлбал, Умард Солонгосын одоогийн удирдагчийг Ким Чен Ун, аавыг нь Ким Чен Ир, өвөөг нь Ким Ир Сен гэж буй нь орос галиг болно. Өөрөөр хэлбэл тэнд болсон болоогүй галигийн тухай ч ойлголт байхгүй. Зүгээр л гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээг орчуулан бэлдэж байгаа нь тодорхой харагдана. Их дээд сургуулийн эрдэмтэн багш нар хүртэл бүтээлдээ нэг улс, нэг хүний нэрийг хэдэн янзаар галигласан нь бүтээлийн чанарыг муутгаж байна. Гэтэл орос, англи хэл нь энэтхэг европ язгуурын, солонгос хэл нь алтай язгуурын хэл болох тул солонгос хэлийг орос, англи хэлний дуудлагаар галиглахаар солонгос дуудлагаасаа бүр ч зөрнө. Умард Солонгосын үе залгамжилсан гурван удирдагчийн овог нэрийг монгол кириллээр галиглавал Ким Жөн-ын, Ким Жөн-ил, Ким Илсөн болно. **Тэгэхээр нийтэд зориулсан, солонгос хэлний дуудлагад аль болох ойр, монгол хүн уншиж дуудахад хялбар галиг зохиох шаардлага бий.** Харин хэлэлцэн шүүгээд нэгэнт тогтсон галигийг дагах аваас энэ нь уг галигийг дагагч хувь хүний болон нийтийн эрх ашигт нийцэх нь дамжиггүй.

	Солонгос үсэг	Ром үсгийн галиг	Орос кирилл үсгийн галиг	Б.Сумьяаб аатар Г.Эрдэнэч имэг	Г.Эрдэнэч имэг	Тайлбар
1	ㅏ	a	а	а	а	
2	ㅑ	eo	э	ө	ө	
3	ㅓ	o	о	о	о, у	Голцуу у-гаар дуудагдана. (Г. Эрдэнэчимэг)
4	ㅕ	u	у	ү	ү	
5	ㅡ	eu	ы	ы	ы	
6	ㅣ	i	и	и	и	
7	ㅞ	ae	э	ай, е	э	ай, е-гээр галиглавал дуудлагаасаа холдоно. (Г. Эрдэнэчимэг)
8	ㅟ	e	е	э	э	
9	ㅛ	oe	ве	ой	Уэ	Цхой, Чой, Чуэ гэж гурван янзаар галигласныг харьцуулбал тодорхой харагдана. (Г. Эрдэнэчимэг)
10	ㅜ	wi	ви	вүй	Вүи	
11	ㅝ	ya	я	я(йа)	я	
12	ㅝ	yeo	йэ/ё/е	е(йө)	ё	
13	ㅞ	yo	ё	ё(йо)	юу	
14	ㅟ	yu	ю	ю(йү)	юү	
15	ㅠ	yaе	йэ	яй	э	
16	ㅡ	ye	йе	е(йэ)	еэ	
17	ㅢ	wa	ва	ва	ва	
18	ㅣ	wae	ве	вай	вэ	
19	ㅤ	wo	вэ,вё	вө	во	
20	ㅥ	we	вэ	вэ	вэ	
21	ㅦ	ui	ый	ый	и	
22	ㅧ	k	к, г	к, г, н	к, г, н	Үгийн эхэнд ‘к’-гаар, үгийн дунд ба эгшгийн хооронд, мөн ㅧ, ㅨ, ㅩ зэрэг гийгүүлэгчийн хойно орсон байвал ‘г’-гээр галиглана. ㅧ, ㅨ, ㅩ зэрэг гийгүүлэгчийн өмнө орсон байвал ‘н’-гээр галиглана. (Б. Сумьяабаатар)
23	ㅨ	kk	кк	г	г	Үгийн эхэнд бол ‘г’- ээр галиглана. (Б. Сумьяабаатар)
24	ㅩ	k	кх	кх	к	Кх-ээр тэмдэглэвэл монгол хүн х-г нь эгшигээр амилуулан дууддаг. Тод жишээ нь Пэхэнян болно. (Г. Эрдэнэчимэг)
25	ㅪ	t, d	т	т, д	т, д	Үгийн эхэнд ‘т’ үгийн дунд ба эгшгийн хооронд ‘д’ – ээр галиглана. (Б. Сумьяабаатар)
26	ㅫ	tt	тт	д	д	
27	ㅬ	t	тх	тх	т	
28	ㅭ	p, b	п	п, б	п, б	Үгийн эхэнд ‘п’ үгийн дунд ба эгшгийн хооронд ‘б’ – ээр галиглана. (Б. Сумьяабаатар)
29	ㅰ	pp	пп	б	б	
30	ㅱ	p	пх	пх	п	

31	ㅈ	j	ч	ч, ж	ч, ж	Үгийн эхэнд 'ч' үгийн дунд ба эгшгийн хооронд 'ж' – ээр галиглана. (Б. Сумьяабаатар)
32	ㅉ	jj	чч	ж, з	ж, з	ж/з – ээр хольж галиглана. (Б. Сумьяабаатар)
33	ㅊ	ch	чх	чх/ц	ц	
34	ㅅ	s	с	с	с, ш	Араас нь , ㅆ, ㅅ, ㅆ, ㅆ, ㅆ орсон бол ш-ээр галиглана. Солонгос хэлэнд си, ся, сё, сю дуудлага байхгүй. (Г. Эрдэнэчимэг)
35	ㅆ	ss	сс	с	с	
36	ㅎ	h	х	х	х	Үг ба үеийн эхэнд х – ээр галиглана. (Б. Сумьяабаатар)
37	ㄴ	n	н	н, нь	н'	Үг ба үеийн эхэнд 'н' – ээр галиглана. Дунд, адагт 'нь' – ээр галиглана. (Б. Сумьяабаатар) Үүнийг нь-ээр галиглах нь бий. Гэтэл монгол хэлэнд гийгүүлэгчийг тагнайшуулан зөөлрүүлж хэлбээс нийт үгийг бүрдүүлж буй бүх авианд нөлөөлдөг. Хатуугийн болон зөөлний тэмдэг төөрөгдөлд оруулж байгаа бол ㅇ, ㄴ хоёрыг ялгалгүй бичсэн нь дээр ч байж болно. (Г. Эрдэнэчимэг)
38	ㅁ	m	м	м	м	
39	ㅇ	ng	н	н	н	нг-ээр галиглах аваас мөн л хоёр гийгүүлэгчийг хоёуланг эгшгээр амилуулан дуудах болно. 송도 -г Сонгодой гэж дуудаж буй нь уг дуудлагаасаа хэт зөрөөтэй.
40	ㄹ	r, l	л, р	р, л, н	р, л, н	Хоёр эгшгийн дунд орвол р-ээр, бусад байрлалд л-ээр тэмдэглэнэ. ㅇ-ийн араас орвол 'н' болно. (Г. Эрдэнэчимэг)

Өмнөх галигаас ямар зөрөөтэйг харуулая.

Солонгос үг	Б. Сумьяабаатар(үсгийн галиг)	Г. Эрдэнэчимэг(авианы галиг)
고려	Корё	Курё
백제	Пайгжэ	Пэгжэ
홍원기	Хон Вёнги	Хун Вён'ги/ Хун Вёнги
노계현	Но Гйэхйёнъ	Ну Гэ-хён'
경희	Кйөнхий	Кёнхи
예맥	Йемайг (ЙемЕг)	Еэмэг
심재용	Сим Жайён (Шим Жайён)	Шим Жэ-юун

Ашигласан хэрэглэгдэхүүн

1. Б. Сумьяабаатар, Г. Эрдэнэчимэг, Солонгос оноосон нэрийг монгол кирилл үсгээр галиглах нь, Солонгос судлал, МУИС, ГХСС, 2005 он
2. Г. Эрдэнэчимэг, Солонгосын түүх, Тэргүүн ба дэд дэвтэр, Адмон, 2006 он
3. Ш. Эгшиг, Галигийн тухай, Хятад хэлний үеийн галиг, монгол хэлээр галиглах журам, Монгол, хятад хэлний орчуулагчдын холбоо, 2016 он
4. 김선일, 한글을 파괴하는 국어의 로마자 표기법, 경향신문, 2016
5. 국어의 로마자 표기법, 문화체육관광부, (국어정책과), 2000
6. 을지바트, 현대몽골어와 한국어의 표기법에 대하여, Монгол солонгос, солонгос монгол орчуулагч нар, групп
7. <https://namu.wiki/국어의 로마자 표기법>
8. <http://saruul.niitlech.mn/content/5036.shtml>

외래어 표기법

-한국어를 중심으로 -

D.Urtnasan (Ph.D)

몽골과학 아카데미
어문연구소 연구원

2023.03.15

발표 내용

- 들어가는 말
 - 외래어 표기법
 - 외래어 표기방법
- 한국어의 몽골 키릴문자 표기
 - 모음 표기
 - 자음 표기
- 맺음말
- 참고문헌

들어가는 말

- 외래어 표기법
- 외국어 전사법 (IPA)

외래어 표기법(transliteration)은 ‘음소의 발음을 고려하지 않고 한 글자를 한 글자로 표기한다.’ (예: *Улаанбаатар-Ulaanbaatar*).
##한 언어의 문자로 되어 있는 단어를 또 다른 언어의 문자로 바꿔 쓰는 것.

외국어 전사법(phonetic transcription)은 ‘어떤 한 언어의 음성들의 조음과 청취를 강조하고 말소리를 전사한다. (예: *Улаанбаатар-[oʎa:ŋpa:tʰər]*).

외래어 표기법

필요성:

- 나라, 도시, 사람의 명칭 등 고유명사의 표기.

예: *Washington Вашингтон*

서울 *Сөүл*, 삼성 *Самсунг*

北京 *Бээжин*

-전문 용어의 표기.

예: 김치 *кимчи* (음식 용어)

(번역하지 않는 용어를 표기한다. 이것은 국제 용어리스트에서 그 용어를 표면적으로 쉽게 알아 볼 수 있게 한다.)

**외래어를 표기할 때 단어의 원래 발음과 형태가 극도로 변화된 경우에 외국어 전사를 사용한다.

예: *safe сейф/*сафе*

외래어 표기법

- 본 언어의 맞춤법과 표준발음법을 위반하지 않는 외래어를 있는 그대로 표기할 수 있음.

예: *мотор, амбиц* (러시아어)

- 본 언어의 표준발음법을 위반하는 외래어를 표준어에 맞게 바꾸어 표기할 수 있음.

예: *фундамент-хундаам* (러시아어)

- 본 언어의 맞춤법을 위반하는 외래어를 철자에 맞게 바꾸어 표기할 수 있음.

예: *image-이미дж-이미ж* (영어)

외래어 표기방법

- 원어민 발음과 제일 가깝게 표기해야 함.

(표기법의 기본 원칙인 소리 나는 대로 (=소리가 들리는 대로) 쓴다에 중점을 두고, 실제 한국어 발음이 몽골어 화자에게 어떻게 들리는가를 고려해야 한다.)

- 한 글자를 한 글자로 표기해야 함.
- 비슷한 음성을 구별할 수 없으면 다른 한 글자로 대신하여 표기해야 함.
- 두 언어의 음운현상을 고려하여 표기해야 함.
 - 조음 위치
 - 조음 방법
 - 변이음 규칙 (무성음화, 원순음화, 구개음화)
 - 음운 변동 규칙 (모음 조화, 이화, 동화 등)

외래어 표기방법

-본 언어의 로마자 표기법을 기준으로 할 수 있다.

-본 언어의 표준말에 따라 표기하는 것을 원칙으로 한다. (서울말, 할흐방언)

한국어의 몽골 키릴문자 표기

- 몽골은 “한국어의 몽골 키릴문자 표기법”을 만들어 그 원칙을 따르지 않아서 러시아의 “한국어의 키릴문자 표기법”을 따라 적는 경우가 있었다. 이 표기는 러시아어의 특징을 나타내기 때문에 몽골 사람의 경우 부적절하다.

예: *평양-Пхьенян-Пён(?)ян, 서울-Сеул-Сөүл*

- 몽골은 1945년 이후부터 키릴 문자를 사용하게 되었다. 이 문자에 외래어를 표기할 수 있는 к, ф, п, щ 4 개의 글자가 있다. 이 글자들은 러시아어에서 들어온 단어를 표기할 때 적절해 보인다 (Дамдинсүрэн, Ц., 1983).

예: *группа-групп, тактик-тактик*

한국어의 몽골 키릴문자 표기 -모음

한국어의 모음 분류표 (이호영, 2003)

혀의 위치	전설모음		중설모음		후설모음	
	비원순	원순	비원순	원순	비원순	원순
고모음	/i/ [i]	/ɥ/ [y]			/ɯ/ [ɯ]	/ɯ/ [u]
중고모음	/e/ [e]	/ɨ/ [ø]	/ɛ/ [ɛ]			/ɤ/ [o]
중저모음	/æ/ [æ]					
저모음			/a/ [a]		/ɑ/ [ɑ]	

몽골어에 전혀 없는 말소리-빨간색
 몽골어에 비슷하게 있는 말소리-초록색
 몽골어에 있는 말소리-검은색

한국어의 몽골 키릴문자 표기 -모음

몽골어 모음 분류표 (Уртнасан, Д., 2022)

혀의 위치	전설모음		중설모음		후설모음	
	비원순	원순	비원순	원순	비원순	원순
고모음	/ɯ/ [i]					/ɯ/ [u]
중고모음	/ə/ [e]	[ɣ]-ху ^{нь}		/ə/ [e]		/y/ [o]
중저모음	[æ]-хан ^ь	[œ]-хон ^ь				/o/ [ɔ]
저모음			/a/ [a]			

한국어에 전혀 없는 말소리-빨간색
 한국어에 비슷하게 있는 말소리-초록색
 한국어에 있는 말소리-검은색

한국어의 몽골 키릴문자 표기 -모음

음성학적 특징:

/-/ [u] -모음은 원순 모음 /o/나 /u/와 같은 후설 모음이지만 /o/, /u/보다 F1, F2(포먼트 값-혀의 위치) 값은 높으며, 비원순 모음이다.

/ㅐ/ [ɛ] - 대부분의 한국인이 한국어의 /ㅐ/ [ɛ] 모음을 /ㅔ/ [e] 모음의 음가로 발음한다 (외국인을 위한 한국어 발음, 2000 :139). 몽골어에는 이 모음과 비슷한 소리가 없지만 몽골인이 한국어 /ㅐ/ [ɛ] 모음과 /ㅔ/ [e] 모음을 구별할 수 있다. 그러나 말할 때는 구별하지 않고 /ㅔ/[e] 모음의 음가로 발음한다. 왜냐하면, 몽골어 /э/ [e] 모음과 /и/ [i] 모음의 혀 위치는 가까운데 한국어 /ㅐ/ [ɛ] 모음과 몽골어 /и/ [i] 모음의 혀 위치는 멀기 때문이다.

/ㅑ/ [y], /ㅓ/ [ø] -몽골어에는 한국어의 /ㅑ/[y], /ㅓ/[ø] 모음과 비슷한 단모음은 없다. 몽골어에는 이중모음이 있어서 몽골인은 /ㅑ/[y], /ㅓ/[ø] 단모음을 이중모음으로 생각하면 된다. 한국어학에는 /ㅑ/[y], /ㅓ/[ø]를 이중모음으로 분리하는 견해도 있다.

/ㅕ/ [ɛ:] (/ㅑ/ [ɹ]) -한국어의 /ㅕ/ [ɛ:], /ㅑ/ [ɹ] 모음과 비슷한 소리로 몽골어의 /o/ [ɔ] 모음을 생각한다. 그러나 한국어의 /ㅕ/ [ɛ:]와 /ㅑ/ [ɹ] 모음은 비원순 모음이며, /ㅕ/ [ɛ:] 모음은 중설 모음이다.

한국어의 몽골 키릴문자 표기 -모음

/ㅓ/ [ɛ], /ㅓ/ [ɔ]-몽골어의 /ㅓ/ [ɛ], /ㅓ/ [ɔ] 모음은 원순 모음이다. 차이는 /ㅓ/ [ɛ] 모음은 중설모음이고 /ㅓ/ [ɔ] 모음은 후설모음이다. 한국어에는 몽골어의 /ㅓ/ [ɛ] 모음과 비슷한 소리는 없다고 볼 수 있다. 몽골어의 /ㅓ/ [ɔ] 모음을 한국어의 /ㅑ/ [ɛ:], /ㅑ/ [ɹ] 모음과 대조하면 몽골어는 원순모음이나 한국어의 /ㅑ/ [ɛ:], /ㅑ/ [ɹ] 모음은 비원순 모음이다.

*** 그래서 '서울'이라는 말을 몽골어로 'Соул'이 아닌 'Севл'이라고 하는 음성학적인 이유가 있을 수 있다.

모음 표기

- 단모음

ㅏ	ㅑ	ㅓ	ㅕ	ㅗ	ㅛ	ㅜ	ㅠ	ㅡ	ㅣ
a	o/ө?	y	ү	ы	и	э/ай?	э	уй	үй

모음 표기

이중 모음

ㅘ	ㅙ	ㅚ	ㅜ	ㅠ	ㅞ	ㅟ	ㅠ	ㅡ	ㅢ	ㅣ
야/йа	ё/йо, йө	ю(ү)/йу	ю(ү)/йү/	йай?	е/йэ	ва/уа	вай/уай	во, вө/үо	вэ/үэ	ый?

한국어의 몽골 키릴문자 표기 -자음

한국어의 자음 분류표 (이호영, 2003)

조음자리		양순음	치(조)음	경구개음	연구개음	성문음
조음방법						
파열음	무기연음	ㅂ	ɸ		ɣ	
	유기경음	ㅃ	ㅌ		к	
	무기경음	ㅍ	ㅍ		г	
파찰음	무기연음			ɕ		
	유기경음			ɕ		
	무기경음			ɕ		
마찰음	무기연음		ɲ			ɣ
	무기경음		ɲ			
비음		ㅁ	л		o	
유음			ㄹ			
반모음		w		j	w, ɥ	

한국어의 몽골 키릴문자 표기 -자음

몽골어 모음 분류표 (Батдорж, Ц., 2022)

조음자리		양순음	치음	치경음	후치경음	경구개음	연구개음
조음방법							
파열음	무기음	б	д				г
	유기음	п	т				к
파찰음	무기음			с	ш		х
	유기음						
마찰음	무성음			з	ж		
	유성음			ц	ч		
	무성음						
	유성음			р			
설측 마찰음	무기음		л				
	유기음		лх				
비음		м	н /н/				η /н/
활음		в				ј	

한국어의 몽골 키릴문자 표기법 -자음

한국어와 몽골어에는 비음 [n], [ŋ] 음소가 둘 다 있지만 몽골어에는 이 두 소리를 같은 글자 'н' 로 표기한다. 몽골어의 경우 음절을 단아서 나타날 때는 [ŋ] 소리로, 어두와 모음 앞에서는 [n] 소리로 나타난다. 그러나 한국어의 경우에는 이 두 가지 소리가 'ㄴ', 'ㅇ'의 다른 글자로 표기되어 있다. 그래서 두 글자를 몽골 키릴문자로 표기할 때 따로 표기할 필요가 생긴다. 음절을 단는 경우와 어말에는 치조 비음 'ㄴ' 을 'нъ'으로, 연구개 비음 'ㅇ'을 'н' 으로 표기하는 것이 적절해 보인다.

예: ㄴ-нъ (문 мунъ, 문단 мунъданъ)

ㅇ-н (상 сан, 선생 сонъсэн)

자음 표기

파열음

ㄱ	ㄲ	ㅋ	ㄷ	ㄸ	ㅌ	ㅍ	ㅂ	ㅃ
г, к	?	к	д, т	?	т	б, п	?	п

파찰음

ㅈ	ㅉ	ㅊ
ж, ч	?	ч

자음 표기

마찰음

ᠠ	ᠨ	ᠬ
с, ш	?	х

비음

ᠯ	ᠮ	ᠨ
н, нъ	м	н

유음

ᠢ	ᠯ, ᠮ
---	------

**표기상의 유의점을 따로 정해야 함.

예: 인명, 지형 지물명, 문화재명, 회사명, 단체명 등은 그 동안 써 온 표기를 쓸 수 있다.

맺음말

구체적이고 체계적인 “한국어의 몽골 키릴문자 표기 규정”을 정해야 함.

***외래어 표기는 대다수가 지키는 “약속”이기 때문에 대표적인 몽골어 음성학자와 한국어 선생님들의 참석이 중요하다.

참고문헌

국어의 로마자 표기법 (문화 관광부 고시 제 2000-8호).

김기성 (2001), “현대 몽골어의 한글 표기에 대해”, *몽골학*, 제11호. pp 267-291.

“외국인을 위한 한국어 발음 47 ”, 2000. Korea Language PLUS, Hangulpark.

이성규, 정윤자 (2008), “음성실험을 바탕으로 한 몽골어 자음과 단모음의 한글 표기”, *몽골학*, 제28호. pp 101-132.

이호영 (2003), *국어음성학*, 태학사.

Дамдинсүрэн, Ц., Осор, Б., (1983), *Монгол үсгийн дүрмийн толь*, Уб.,

Уртнасан, Д., Батдорж, Ц., Батхишиг, С., (2022), *Авиа зүй-Монгол хэл судлал 8-р боть*, Уб.,

Urtnasan Davaajav (2020), “A Constrastive study of vowel sounds in Mongolian and Korean” *Language and cultural exchange*, Vol.I, No.1, pp.80-100.